

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/001/НА-СТА-ТТЗ

Чингис хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Д.Эрдэнэтуяа
Утас: 99569599

Цахим хаяг: www.audit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГН.....	2
Аудитын гол асуудал	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТЭГСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Төлбөрийн акт.....	15
5.2 Албан шаардлага	15
5.3 Зөвлөмж	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	17
.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 496
танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ГАЛШАР СУМЫН
ЗАСАГ ДАРГА Т.ЭНХЧУЛУУН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар сумын Засаг даргын 291,729.1 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 17,109.1 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 13,995.5 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 541,161.2 мянган төгрөг, нийт 863,994.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- ✓ Тайлант оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгүүлэх 8 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.
- ✓ Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг дутуу төлөвлөсөн байна.
- ✓ ИТХ-аар баталсан үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого, бусад орлого, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг дутуу бүрдүүлсэн байна.
- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй анхны өртгөөрөө элэгдлээ бүрэн нөхсөн 108 нэр төрлийн хөрөнгийн талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

- ✓ Цалингийн зардал, Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас шагнал олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- ✓ Эд хариуцагчийн хувийн харилцах дансаар Галшар адууны баяр зохион байгуулах зардлыг гаргаж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- ✓ Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтын олговортой цалин давхардуулж, 3 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг илүү олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
- ✓ Тайлант онд байгууллагын ахмадын сангийн зардлаас гадны байгууллагын ахмадуудад хүндэтгэл, дэмжлэг үзүүлсэн, үндсэн үйл ажиллагааны зардлаас сумын ИТХ-ийн төлөөлөгч нарт томилот олгосон, хичээл үйлдвэрлэлийн зардлаас малчид хоршоологчдын зөвлөгөөний сургалтын зардалд зарцуулсан байна.
- ✓ Сумын ИТХ-ын 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалинг илүү тайлагнасан байна.
- ✓ Анхан шатны баримтыг үндэслэж нягтлан бодох бүртгэл хөтөлдөггүй зөрчлийг давтан гаргаж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн "Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ" төсөл, арга хэмжээний хүрээнд улсын төсвөөс санхүүжүүлдэг шүлхий өвчний тарилгын ажил гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд шатахууны зардал олгож хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- ✓ Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.

Энэ нь дараах хууль тогтоомж, тушаал шийдвэрийн холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах"
- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах".
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "Илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох"
- ✓ Аймгийн иргэдийн Төлөөлчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-н ы өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан "орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”
- ✓ Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.5 дахь хэсэг “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх эх үүсвэрийг өөр бусад эх үүсвэртэй уялдуулан төлөвлөсөн байх;”
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.”
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”,
- ✓ Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 20 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,099,400.5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,098,185.6 мянган төгрөгийг урсгал зардалд, 789,214.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар, 212,000.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийг санхүүжүүлэхээр төлөвлөж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,689,215.2 мянган төгрөг буюу 86.7 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Галшар сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 293,876.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 2,148.2 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 278,570.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 13,157.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутгийн төсөвт 446,050.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 556,234.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 110,184.5 мянган төгрөгөөр буюу 124.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх үүрэгтэй боловч 54.5.4 "Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/ тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд дараагийн аудитад санхүүгийн тайлангийн бүрдлийг бүрэн хангах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТЭГСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		962,479.18	1,410,869.47
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	691,650.28	540,435.78
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	91,103.8	323,401.83
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	431,964.8
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	147,775.1	90,874.57
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	31,950	24,192.5
7	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		4,251,299.14	4,327,634.38
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	4,251,299.14	4,327,634.38
9	1.2.2.02 Биет хөрөнгө		4,204,199.64	4,280,664.38
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	47,099.5	46,970
11	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		5,213,778.32	5,738,503.85
12	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		5,213,778.32	5,738,503.85
13	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		5,213,778.32	5,738,503.85
14	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		415,237.04	415,237.04
15	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		4,755,907.02	5,280,632.54
16	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		42,634.27	42,634.27
17	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		5,213,778.32	5,738,503.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруу лга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,410,378.41	2,902,405.68
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		578,623.66	553,472.09
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		381,148.69	364,738.83
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		381,148.69	364,738.83
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		58,486.15	43,996.09
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		138,988.82	144,737.18
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	842,454.28	2,348,933.59
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	1,325,430.63
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,989,300.46	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,926,529.53	2,165,695.9
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		1,926,529.53	2,165,695.9
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,870,639.71	2,149,260.63
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		772,530.36	883,059.09
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		95,389.13	118,894.65
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		381,915.34	453,282.02
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		56,184.7	111,650.36
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		0.0	130
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		76,622.6	85,969.93
19	1.1.2.01.1.07 Томилонт, зочны зардал		26,620	26,300
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		42,578.79	70,273.32
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		418,798.79	399,701.24
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		55,889.81	16,435.27
23	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,483,848.88	736,709.78
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		696,215.79	211,984.25
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)- (V)		-696,215.79	-211,984.25
26	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		787,633.1	524,725.53

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,593,998.4	2,557,156.05
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	578,623.66	553,472.09
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	381,148.69	364,738.83
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	58,486.15	43,996.09
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	138,988.82	144,737.18
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	20,756.05	46,040.79
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	6,853.37	11,188.99
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	111,379.4	87,507.4
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,331.67	2,003,683.96
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	25,331.67	16,962.33
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,322,220.63
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	664,501
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,990,043.07	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,684,856.96	1,791,386.68
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,684,856.96	1,791,386.68
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,629,799.65	1,770,421.31
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	775,875.86	883,119.09
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,052.83	113,055.46
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	381,915.34	453,282.02
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	62,153.92	48,016.28
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	1,807.1	2,653
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	92,202.8	107,657.3
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	26,796	26,300
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,720.79	73,802.22
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	144,275.01	62,535.93
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	55,057.31	20,965.37
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	909,141.43	765,769.37
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	704,695.59	704,983.88
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	704,695.59	704,983.88
30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	704,695.59	704,983.88
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-704,695.59	-704,983.88
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	212,000
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-212,000
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	204,445.85	-151,214.51
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	487,204.44	691,650.28
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	691,650.28	540,435.78

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан*/ мянган төгрөг/*

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,370,589.75	4,370,589.75
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	55,555.48	55,555.48
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,426,145.23	4,426,145.23
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	787,633.1	787,633.1
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,213,778.32	5,213,778.32
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,213,778.32	5,213,778.32
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,213,778.32	5,213,778.32
8	1.7 Тайлант үеийн үр дүн	524,725.53	524,725.53
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,738,503.85	5,738,503.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөөлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Ч	3.1.01.1 НИИТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,157,839.80	3,982,673.46	175,166.34	96
Ч1	3.1.01.1.1 Татварын орлого	430,050.00	553,472.09	(123,422.09)	129
Ч10	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	300,000.00	364,738.83	(64,738.83)	122
Ч100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	300,000.00	364,738.83	(64,738.83)	122
Ч10001	болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	200,000.00	260,063.19	(60,063.19)	130
Ч10002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	82,000.00	83,322.59	(1,322.59)	102
Ч10003	3.1.01.1.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	18,000.00	21,234.16	(3,234.16)	118
Ч10004	3.1.01.1.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	-	118.89	(118.89)	
Ч13	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	35,700.00	43,996.09	(8,296.09)	123
Ч13001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	35,000.00	24,472.59	10,527.41	70
Ч13002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	700.00	1,440.00	(740.00)	206
Ч13004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	-	18,083.50	(18,083.50)	
Ч18	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	94,350.00	144,737.18	(50,387.18)	153
Ч180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	32,000.00	46,040.79	(14,040.79)	144
Ч18001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	6,000.00	17,684.59	(11,684.59)	295
Ч18006	төлбөр	16,000.00	16,250.00	(250.00)	102
Ч18009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10,000.00	12,106.20	(2,106.20)	121
Ч181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	10,000.00	11,188.99	(1,188.99)	112
Ч18101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	10,000.00	11,188.99	(1,188.99)	112
Ч182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	52,350.00	87,507.40	(35,157.40)	167
Ч18202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	52,350.00	87,507.40	(35,157.40)	167
Ч2	3.1.01.1.2 Татварын бус орлого	3,727,789.80	3,429,201.37	298,588.43	92
Ч20	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	16,000.00	13,132.33	2,867.68	82
Ч20003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	3,000.00	2,762.50	237.50	92
Ч20004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	10,000.00	8,369.83	1,630.18	84
Ч20010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	2,000.00	2,000.00	-	100
Ч20009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.00	-	1,000.00	-
Ч22	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	3,047,288.80	2,751,568.05	295,720.75	90
Ч22003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэл ээс авсан татаас	1,306,619.40	1,306,619.40	-	100
Ч22005	3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих	1,740,669.40	1,444,948.65	295,720.75	83
Ч23	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	664,501.00	664,501.00	-	100
Ч23002	орлого	664,501.00	664,501.00	-	100
21	3.1.01.2 НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,099,400.50	4,481,780.07	(1,382,379.57)	145
21	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	2,098,185.60	3,567,196.20	(1,469,010.60)	170
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,085,040.80	1,764,352.29	320,688.51	85
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	983,916.00	883,119.09	100,796.91	90
210101	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	478,200.00	422,432.58	55,767.42	88
210102	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	338,983.20	311,137.61	27,845.59	92
210103	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	59,250.80	48,373.47	10,877.33	82
210104	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	31,482.00	25,380.86	6,101.14	81
210105	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	76,000.00	75,794.57	205.43	100
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	424,633.30	113,055.46	311,577.84	91
210201	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	85,166.70	81,703.32	3,463.38	96
210202	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	9,866.70	8,697.53	1,169.17	88
210203	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	4,933.30	3,857.67	1,075.63	78
210204	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	4,933.30	3,514.03	1,419.27	71
210205	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	19,733.30	15,282.91	4,450.39	77
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	524,204.10	453,282.02	70,922.08	86
210301	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	101,853.00	48,776.13	53,076.87	48
210302	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	413,508.10	398,247.40	15,260.70	96
210303	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	8,843.00	6,258.50	2,584.50	71
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	55,311.10	42,562.15	12,748.95	77
210401	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	6,779.80	5,748.10	1,031.70	85
210402	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	38,100.00	31,428.70	6,671.30	82
210403	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,610.30	2,178.00	2,432.30	47
210405	ариулгал	1,563.80	-	1,563.80	-
210406	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,257.20	3,207.35	1,049.85	75
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	4,807.10	2,653.00	2,154.10	55
210503	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,807.10	2,653.00	2,154.10	55
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	118,349.60	109,927.30	8,422.30	93
210601	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	20,549.90	19,255.70	1,294.20	94
210603	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	943.10	308.60	634.50	33
210604	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	96,856.60	90,363.00	6,493.60	93
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	31,899.00	24,900.00	6,999.00	78
210702	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	31,899.00	24,900.00	6,999.00	78
2108	хураамж	156,045.10	72,587.33	83,457.77	47
210801	үйлчилгээний төлбөр хураамж	147,728.20	66,554.63	81,173.57	45
210802	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	961.70	-	961.70	-
210803	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	1,014.30	1,014.00	0.30	100
210804	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	536.40	343.75	192.65	64
210805	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	245.60	120.00	125.60	49
210806	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,595.40	616.00	979.40	39
210807	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	3,963.50	3,938.95	24.55	99
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	85,885.50	62,265.93	23,619.57	72
210901	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	70,439.40	48,976.53	21,462.87	70
210902	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,446.10	13,289.40	2,156.70	86
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,144.80	1,802,843.91	(1,789,699.11)	
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	1,792,564.85	(1,792,564.85)	
213103	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	-	1,792,564.85	(1,792,564.85)	
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	13,144.80	10,279.06	2,865.74	78
213209	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, цагнал урамшуулал	13,144.80	10,279.06	2,865.74	78
22	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	789,214.90	702,583.88	86,631.02	89
223001	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	789,214.90	702,583.88	86,631.02	89
23	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	212,000.00	212,000.00	-	100
230001	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	212,000.00	212,000.00	-	100
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ	1,058,439.30	(499,106.61)	1,557,545.91	(47)
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(1,058,439.30)	499,106.61	(1,557,545.91)	(47)
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(1,058,439.30)	499,106.61	(1,557,545.91)	(47)
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	691,649.08	(691,649.08)	
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	540,158.68	(540,158.68)	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
/ мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИИТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	15,601.23
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,601.23
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	15,601.23
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	15,601.23
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	15,601.23
350014	төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,160.93
350015	нэмэлт орлого	5,440.31
II	1.1.1.2 НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,199.02
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	13,199.02
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,199.02
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	5,454.13
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	199.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	4,649.13
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	176.00
210406	1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	430.00
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	130.00
210601	1.1.1.2.1.1.6.1 Багаж, техник, хэрэгсэл	130.00
2107	1.1.1.2.1.1.7 Томилолт, зочны зардал	1,400.00
210702	1.1.1.2.1.1.7.2 Дотоод албан томилолт	1,400.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,214.89
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	764.89
210806	1.1.1.2.1.1.8.6 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450.00
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,000.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	5,000.00
213209	1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урам шуулал	5,000.00
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИИТ ТЭНЦЭЛ	2,402.21
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,402.21)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,402.21)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Галшар сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 2 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал нийт 9 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад санал дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газарт аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж "Хязгаарлалттай" дүгнэлт, Эрүүл мэндийн төвд Платиниум прогресс аудит ХХК, Хүүхдийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуульд Ари файнэнс аудит ХХК аудит хийж тус тус "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт гаргасан байна.

5.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 838,521.9 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 266,256.0 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 1,848.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 557,338.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт: Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Засаг даргын тамгын газар:

- ✓ Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 221,488.7 мянган төгрөгийг тохируулаагүй алдааг аудитын явцад залруулав.
- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд анхны өртгөөрөө элэгдлээ бүрэн нөхсөн 108 нэр төрлийн 411,882.1 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Ашиглах боломжтойг дахин үнэлэх, ашиглалтын шаардлага хангахгүй болсон хөрөнгийг данснаас хасах арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

- ✓ Аймгийн засаг даргын захирамжийг үндэслэн цалингийн зардлаас 2,274.0 мянган төгрөгийг шагналд олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

- ✓ Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 4,268.0 мянган төгрөгийг шагнал урамшуулалд, эд хариуцагчийн харилцах дансаар 5,605.0 мянган төгрөгийг Галшар адууны баярт, нийт 9,873.3 мянган төгрөгийг зарцуулж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

- ✓ Тайлант онд 3 ажилтанд ээлжийн амралтын олговортой давхардуулж 1,019.2 мянган төгрөгийг, 3 албан хаагчид ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэлд 829.0 мянган төгрөгийг илүү олгож, нийт 1,848.2 мянган төгрөгийн төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- ✓ Тайлант онд байгууллагын ахмадын сангийн зардлаас гадны байгууллагын ахмадуудад хүндэтгэл, дэмжлэг үзүүлж 420.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны томилолтын зардлаас ИТХ-ийн төлөөлөгчийн томилолтод 400.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас малчид хоршоологчдын зөвлөгөөний сургалтын зардалд 500.0 мянган төгрөг шилжүүлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Тайлант оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд олгогдоогүй 2,709.5 мянган төгрөгийн цалин илүү тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Шатахуун, бичиг хэргийн материалыг орлого авалгүй шууд зардалд бичсэн 2,737.7 мянган төгрөг, бараа материалыг цалингийн зардалд хаасан 833.2 мянган төгрөг, санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 4,608.6 мянган төгрөгөөр бууруулж бүртгэсэн, нэмэлт санхүүжилтийн орлогыг 620.0 мянган төгрөгөөр илүү, төвлөрүүлэх шилжүүлгийг 1,840.0 мянган төгрөгөөр дутуу, авлагыг 2,170.0 мянган төгрөгөөр дутуу, бараа материалын 270.0 мянган төгрөгийн үлдэгдлийг төрийн харилцах дансны үлдэгдлээр тайлагнаж анхан шатны баримтыг үндэслэж нягтлан бодох бүртгэл хөтөлдөггүй зөрчлийг давтан гаргаж өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан:

- ✓ Тайланд 18,083.5 мянган төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих болон малын тоо толгойн албан татварын орлогыг салгаж тусгаагүй алдааг залруулсан.
- ✓ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн "Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ" төсөл, арга хэмжээний хүрээнд улсын төсвөөс санхүүжүүлдэг шүлхий өвчний тарилгын ажил гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд шатахууны зардал олгож 1,205.2 мянган төгрөгийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг, төсөвгүй төсөл, арга хэмжээнд 539,956.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж гэрээ байгуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

Хоршоо хөгжүүлэх сан:

- ✓ Санхүүгийн тайланд 2025 онд олгосон зээлийн хүү 26,683.7 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй алдааг залруулсан.

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 55,828.8 мянган төгрөгийн 15 алдаа, зөрчил илэрснээс 45,672.0 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 1,565.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 2,171.4 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүлж, 6,419.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн байна.

Аудитын илрүүлэлт: Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Ерөнхий боловсролын сургууль:

- ✓ Тайлант онд худалдаж авсан 39,918.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг мөнгөн гүйлгээний тайланд бараа үйлчилгээний зардлаар бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.
- ✓ Гурван нэр төрлийн 1,610.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн алдааг аудитын явцад залруулав.
- ✓ Түрээсийн ном сурах бичгийг бараа хангамжийн материал дансанд багцлаж бөөн дүнгээр бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

- ✓ Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгэсэн боловч тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

Соёлын төв:

- ✓ Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 2,352.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитын явцад залруулав.
- ✓ Санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 1,791.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан алдааг аудитын явцад залруулав.
- ✓ Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч өөртөө тушаал гаргаж 152.5 мянган төгрөгийн түлээ, нүүрсний хөнгөлөлт авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

- ✓ Ажилтны 635.8 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаж аваагүй, ээлжийн амралтын хоногийн тооцоо хийгээгүйгээс 3 ажилтанд ээлжийн амралтын олговортой давхардуулж 543.5 мянган төгрөгийн цалин олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

Цэцэрлэг:

- ✓ Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 13 нэр төрлийн (анхны өртөг 10,675.0 мянган төгрөг) хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

- ✓ Цалингийн журналын дүнг татвар, нийгмийн даатгалын тайлантай тулган шалгахад хувь хүний орлогын албан татварын тайланг 1,136.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

- ✓ Ур чадварын нэмэгдлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, аудитын дүгнэлт өөрчлөлтгүй, 2024 оны төлөвлөгөөний биелэлт 97.0 хувиар үнэлэгдсэн үзүүлэлтээр цэцэрлэгийн эрхлэгчид 20 хувиар тооцож 2,171.4 мянган төгрөг ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Байгууллагын даргын тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого зохион байгуулах комиссыг томилж хөрөнгийн тооллогыг гүйцэтгүүлсэн боловч тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

- ✓ Ур чадварын нэмэгдлийг хагас жил дутамд шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнээгүй, нотлох баримтгүй, амжилтын түвшний хувийг 2 ажилтанд илүү тооцож 233.8 мянган төгрөг олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон

Галшар сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл:

Аудитаар 2,148.2 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа.

- ✓ 2025 оны 12 дугаар сарын 30.31-ны өдрүүдэд арилжааны банкнаас шилжүүлсэн албан татвар, төлбөр, хураамжийн замд яваа мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан алдааг залруулсан.

Аудитаар нийт 291,728.1 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 278,570.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 13,157.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

Байхгүй.

5.2 Албан шаардлага

- ✓ Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч урьд оны хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 7,434.2 мянган төгрөгийг дутуу төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн

5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:”, 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”, 14.2.4-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;” гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг энэ тайлангийн 19-20 дугаар хуудсанд харуулав.

Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт: Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлогыг 10,527.4 мянган төгрөг, бусад орлогыг 1,000.0 мянган төгрөгөөр, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг 1,630.7 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1: 41.2.Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж байх.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэсэн заалтын дагуу төлөвлөгөөг 1 сарын дотор, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	2,148.20	1	2,148.20			1	2,148.20				
ЗДТГ	1	221,488.77			1	221,488.77	1	221,488.77				
ОНХСан	1	18,083.50			1	18,083.50	1	18,083.50				
ХХСан	1	26,683.78			1	26,683.78	1	26,683.78				
ОН-ийн байгууллагын дүн	4	268,404.26	1	2,148.20	3	266,256.06	4	268,404.26	0	0.00	0	0.00
Соёлын төв	2	4,143.18			2	4,143.18	2	4,143.18				
ЕБС	2	41,528.90			2	41,528.90	2	41,528.90				
УТ-ийн байгууллагын дүн	4	45,672.08	0	-	4	45,672.08	4	45,672.08	0	-	0	-
Дүн	8	314,076.33	1	2,148.20	7	311,928.13	8	314,076.33	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	2	20,591.84			1	7,434.26	1	13,157.58
ЗДТГ	4	13,995.59	1	1,848.24	2	12,147.35	1	-
ИТХ	3	17,109.11			3	17,109.11		
ОНХСан	2	541,161.20			2	541,161.20		
ОН-ийн байгууллагын дүн	11	592,857.74	1	1,848.24	8	577,851.92	2	13,157.58
ЕБС	3	5,282.93			2	-	1	5,282.93
Цэцэрлэг	6	3,542.00	1	233.85	3	2,171.44	2	1,136.71
Соёлын төв	2	1,331.85	2	1,331.85				
УТ-ийн байгууллагын дүн	11	10,156.78	3	1,565.70	5	2,171.44	3	6,419.64
Дүн	22	603,014.52	4	3,413.94	13	580,023.36	5	19,577.22

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	-	0	-	0	-	0	-
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Засаг дарга	1	271,136.26	0	-	1	271,136.26	0	-
ОН-ийн байгууллагын дүн	1	271,136.26	0	-	1	271,136.26	0	-
УТ-ийн байгууллагын дүн	0	-	0	-	0	-	0	-
Нийт дүн	1	271,136.26	0	-	1	271,136.26	0	-



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 273-А2371125
ХЭА-2026/001/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 271,136,260.00 (хоёр зуун далан нэгэн сая нэг зуун гучин зургаан мянга хоёр зуун жаран) төгрөгийн 8 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Т.Энхчулуун-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Д.ЭРДЭНЭТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 274-А2371125
ХЭА-2026/001/НА-СТА-ТТЗ Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдэл 7,434,265.00 (долоон сая дөрвөн зуун гучин дөрвөн мянга хоёр зуун жаран таван) төгрөгийг бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх," 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх," 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах," гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Т.Энхчулуун-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Д.ЭРДЭНЭТУЯА